

**МОНГОЛ УЛС, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН СЭРГЭЭН  
БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН БАНК ХООРОНДЫН “ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН  
ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСЛИЙН III ҮЕ  
ШАТ”-НЫ ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ  
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа дээрх зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс энэхүү хэлэлцээрээр Улаанбаатар хотын төв хэсгийн 50 гаруй мянган хэрэглэгч болон Төрийн ордон, Улсын төв эмнэлгүүдийн эрчим хүчний найдвартай байдлыг хангах зорилгоор, Германы Сэргээн босголтын зээлийн банкны 17 сая еврогийн хөнгөлөлттэй санхүүжилтээр сүүлийн үеийн технологи бүхий 110 кВ-ын хаалттай дэд станцыг 2026-2028 онд барьж байгуулахаар тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн зөвлөх үйлчилгээнд зарцуулах төсөв, төслийн үр ашгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл эрчим хүчний системийн найдвартай байдлыг хангах бодит шийдэл, төлөвлөгөөний талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат иргэд 20 кВт хүртэлх нарны станцаар үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг бодитоор авч чадаж байгаа эсэх, иргэд, аж ахуйн нэгжүүдийн эрчим хүч нийлүүлэх тарифын зөрүүний талаар, мөн Улсын Их Хурлын 2025 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилт, эрчим хүчний салбарын либералчлалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төсөл хэрэгжих байршил болон сонгон шалгаруулалтын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд асуулт асууж, хариулт авч дууссаны дараа Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд зээлийн хүү бага боловч төслийн шугам, дэд станц, зөвлөх үйлчилгээ зэрэг бодит төслийн өртөг хэт өндөр байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа төслийн дагалдах зардлуудаас шалтгаалан нийт өртөг өндөр байгаа, мөн төслийн үр ашиг, зардлын хяналтыг сайжруулах шаардлагатай бөгөөд цаашид олон улсын зээлийн эргэн төлөлтийг татвар төлөгчдийн мөнгөөр биш, тухайн төслийг

хэрэгжүүлэх салбар болон төрийн өмчит компаниуд өөрсдийн орлогоор хариуцах санхүүгийн сахилга бат, төлөвлөгөөг хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төслийн зөвлөх үйлчилгээний зардлын дүн, үндэслэл, шаардлагын талаар тус тус санал хэлсэн болно.

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Р.СЭДДОРЖ**